

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 16 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 26 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 21ы минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын албаны дарга- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга- Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Доньжчимбуугийн Бямбадоржийг Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын албаны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн дүгнэлт гаргаж, Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Далхжавын Оюунчимэгийг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны</p>

		<p>удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн дүгнэлт гаргаж, Төрийн нарийн бичгийн дарга А.Эрдэнэтуяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Ядамсүрэнгийн Буянжаргалыг Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн дүгнэлт гаргаж, Төрийн нарийн бичгийн дарга А.Эрдэнэтуяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
2	<p>УИХ-ын гишүүнээр 2000-2004 онд ажиллаж байсан Б.Долгорыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 2000-2004 онд сонгогдон, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар 2006-2012 онд томилогдон ажиллаж байсан Бадраагийн Долгорыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Төв, Хэнтий аймаг болон Зам тээврийн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17</p>

<p>яам, Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Газрын тосны газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 05 дугаар сарын 01, 06-ны өдрүүдэд Төв аймаг, Хэнтий аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төв аймаг, Хэнтий аймагт 2014 оны 05 дугаар сарын 01, 06-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий нийт 98 иргэнээс 38 иргэн /Төв аймагт 15, Хэнтий аймагт 23/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 60 иргэн /Төв аймагт 22, Хэнтий аймагт 38/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 5, 6, 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэн /Төв аймагт 6, Хэнтий аймагт 7/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 24 иргэн /Төв аймагт 11, Хэнтий аймагт 13/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 5-8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 37 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг</p>
---	--

сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөл /Д.Нямдорж/-д, Хэнтий аймаг дахь салбар зөвлөл /М.Болд/-д тус тус үүрэг болгох.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 63 иргэнийг "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэх.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 25 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь

		<p>томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 25 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тус тусын албан тушаалд томилохыг тухайн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ